

Магистрын сургалтын үр дүн багшийн судлаач хандлагад нөлөөлөх нь

Э.Октябрьжаргал^{*а}, С.Батцэцэг^б, Б.Баярмаа^б

Монгол Улсын Боловсролын Их Сургууль,

Боловсрол судлалын сургууль,

^аСэтгэл судлал арга зүйн тэнхим

^бСудалгааны арга зүйн тэнхим

Хураангуй

“МУБИС-ийн хөгжлийн бодлогод (2014-2024) Олон улсын чиг хандлага, өөрийн орны бодлоготой уялдуулан, хүүхэд бүрийг хөгжүүлэх чадамжтай, бүтээлч багш бэлтгэн гаргахад чиглэсэн байдлаар шинэ зууны багшийн загвар (үр дүн)-т суурилсан багш боловсролын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж тогтмол сайжруулалт хийнэ” хэмээн тусган хэрэгжүүлснээс хойш магистрын сургалтад хамрагдаж буй суралцагчдын тоо 1.6 дахин өссөн байна. Багш сурган хүмүүжүүлэгчид судлаач хандлагатай байж, судалгаа шинжилгээний ажилд идэвхтэй оролцсоноор багш боловсролын суурь мэдлэг болон практик чадвар улам бүр сайжирдаг. Багшийн судлаач хандлага нь судалгааны ажилд хандах сэтгэл хөдлөл, судалгааны ажлын талаарх мэдлэг, чадвар болон судалгаа хийж буй зан үйлээр илэрнэ. Бид багшийн судлаач хандлагыг судлахдаа МУБИС-ийн магистрын сургалтад хамрагдаж буй магистрантуудын 20 хүртэлх хувийг хамруулан судалсан. Багшийн судлаач хандлагыг хэмжих аргачлал нь 1. Судалгааны ажлын арга зүйн мэдлэг эзэмших хандлага 2. Судалгааны ажилд ач холбогдол өгөх хандлага 3. Багш судалгааны ажлыг хэрэглэх хандлага 4. Судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлагаар хэмжигдэх боломжтой юм. Судалгааны ажилдаа “Багшийн судлаач хандлагыг хэмжих аргачлал”, ярилцлагын аргууд болон SPSS-23, NVivo-11 программуудыг хэрэглэсэн.

Түлхүүр үг

Судлаач хандлага, мэргэжлийн хөгжил, сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, зан үйл

Удиртгал

Өнөөгийн багшийн хандлагыг өөрчлөх талаар маш их ярих болсон төдийгүй итгэл үнэмшил, өөрийн үр дүнтэй байдал, сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх, ажлын бүтээмж, анги зохион байгуулалт болон суралцагчидтай харилцах харилцаа зэрэг нь багшийн чанарт хамгийн их нөлөөлөх хүчин зүйлүүд хэмээн тодорхойлох болжээ. Хандлага нь нийгмийн сэтгэл судлалын шинжлэх ухааны цөм асуудлын нэг. Энэ ухагдахууныг дараах байдлаар тодорхойлж байна: “Хувь хүн, эд юмс болон асуудалд (үйл явдалд) үзүүлэх дүгнэлтэд (үнэлгээт) хариу үйлдлийн тогтсон загвар төлөв хэмээн түгээмэл ишлэгддэг сонгодог тодорхойлолт ёсоор энэ нь сэтгэцийн объектуудад үзүүлж байгаа зохих эрэмбэ бүхий сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, зан үйлийн хариу үйлдлүүд (мэдрэмж, сэтгэлгээ, биеэ авч явах байдал), энэхүү тодорхойлолтод тусгагдсан эрэмбэ нь ихэвчлэн бодит байдалд төдийлөн нийцэхээргүй таамаг байх бөгөөд хэзээ ч учирч байгаагүй зүйлд хандах хандлага байж болно (Andrew M. Colman, 2006, p. 16). Аффект

гэдгийг Оксфордын сэтгэл судлалын тайлбар тольд “Сэтгэлийн хөдөлгөөн буюу аз жаргал, уйтгар гуниг, айдас, уур хилэн зэрэг субьектив байдлаар илэрч байдаг мэдрэмжүүдийг хэлнэ. Илэрхийллийн эрч хүч нь мэдэгдэхүйц буурсан бол сул сэтгэл хөдлөл, илэрхийлэл огт байхгүй эсвэл бараг байхгүй бол тодорхойгүй сэтгэл хөдлөл, сэтгэлийн хөдөлгөөнгүй үе гэж тус тус нэрлэнэ.

Багш мэргэжлийн хөгжлийн өнөөгийн талаарх ойлголтыг улам боловсронгуй болгох, түүнийг хэмжин судлах хэмжигдэхүүнээр өөрийн орны багш нарын судлаач хандлагад тулгуурласан болно. Нэгдүгээрт багш сурган хүмүүжүүлэгчийн судлаач хандлагын онолын тогтолцоог тодорхойлох (Tack and Vanderlinde 2014). Хоёрдугаарт багшийн судлаач хандлагыг хэмжих судалгааны арга зүйн чиг баримжаалал онцлогийг судалсан. Багш мэргэжлийн хөгжилд багш судлаач байх нь ихээхэн чухал үүргийг гүйцэтгэдэг. Багшийн судлаач хандлагыг хэмжихдээ багшийг судалгааны ажилд хандах хандлагаар нь дараах хэд хэдэн бүлгүүдэд хуваан

авч үздэг. 1. Багшийн судалгаа шинжилгээний ажилд татагдах хүсэл сонирхлын цар хүрээ. 2. Багшийн судлаач байх үүрэг, үйл ажиллагааны цар хүрээ. Зөвхөн багшийн судалгаа, шинжилгээний ажилд татагдах сонирхол төдийгүй хамгийн гол нь багшийн итгэл үнэмшил чухал нөлөөлөл үзүүлэх юм. 3. Багшийн судалгааны арга зүйн мэдлэг, танин мэдэхүйн цар хүрээ.

Багш сурган хүмүүжүүлэгчийн судалгааны аргазүйн мэдлэг, түүнд бүтээлч хандах хандлагыг үнэлэх аргачлал боловсруулан Монгол Улсын Боловсролын Их сургуулийн магистрантурт суралцаж буй ЕБС-ийн багш нарыг хамруулан судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны ажлыг цаашид хамрах хүрээг улам өргөжүүлэн, үр дүнд тулгуурласан үйл ажиллагаа явуулснаар багшийн судлаач хандлагыг бодитой хэмжин, багш судлаач байх чиг хандлагыг төлөвшүүлэх боломжтой гэж үзэж байна.

Үндсэн хэсэг

Багш сурган хүмүүжүүлэгчийн мэргэжлийн хөгжил хэмээх ойлголт нь багшийн судлаач хандлагатай салшгүй холбоотой төдийгүй багшийн судлаач хандлагыг төлөвшүүлэхэд сургалтын үр нөлөө ямар байгааг тандах зорилготой.

Судалгааны зорилт нь багшийн судлаач хандлагыг дэд бүлгүүдээр тодорхойлох замаар багшийн мэргэжлийн хөгжил, үр чадварыг үр дүнтэй дээшлүүлэхэд чиглэсэн юм.

Багшийн судлаач хандлагыг хэмжих болсон шалтгаан: ЕБС-ийн 80 гаруй багш нартай дөрвөн удаагийн давтамжтай хэлэлцүүлэг хийсний үр дүнд боловсролын чанар, багшийн хөгжилд судлаач багшийн оролцоог чухалчилсан

юм. Хэлэлцүүлэг бүр нь өөр өөрийн огцлог бүхий дараах сэдвийн хүрээнд хийгдсэн. “Бид судлаач багш мөн үү”, “Яавал бид судлаач багш болох вэ”, “Багш судлаач байх нь ямар давуу талтай вэ” зэргээр хэлэлцэж ярилцсан болно.


Судалгааны арга зүй, хамрах хүрээ: МУБИС-ын магистрантурт суралцаж буй ЕБС-ийн багш нар “Багшийн судлаач хандлагыг тодорхойлох” аргачлалын 20 үзүүлэлтээр өөрийгөө үнэлэх асуулгын аргыг үндсэн арга болгон хэрэглэсэн. Фактор анализын үр дүнгээр дэд бүлгүүд болгож элсэх, төгсөх үеийн ялгааг бүтцээр харьцуулан шалтгааны талаар өгсөн ярилцлагын мэдээллийг нэгтгэж судалгааг зохион байгуулав. Оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгосон бөгөөд элсэгч магистраас 30, төгсөх ангийн магистрантураас 17 хамрагдсан.

Судалгааны үр дүн: Нийт судлуулагчдын 84% нь эмэгтэй, 16% нь эрэгтэй багш нар хамрагдсан. Багшаар ажилласан жилийн дундаж 6 бөгөөд эдгээр багш нарын ихэнх 5 жил ажилласан байв. Багш нарын насны дундаж 28 орчим, орон нутгийн багш нар 60%, нийслэлийн багш нар 40%-тай байлаа.

Судлуулагч багш өөрийн судлаач хандлагыг үнэлэхдээ 20 үзүүлэлтээр 1-5 хүртэлх оноог өгч хэмжээсжүүлсэн бөгөөд фактор анализын үр дүнд судалгааны арга зүйн мэдлэг эзэмших хандлага, судалгааны ажилд ач холбогдол өгөх хандлага, судалгааны ажлыг хэрэглэх хандлага, судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлага гэсэн дэд бүлгүүдэд багцлан боловсруулалт хийсэн үр дүнгээс харахад (1,2), (1,3) ба (2, 4) дүгээр бүлгүүд хүчтэй хамааралтай, бусад бүлгүүдийн хооронд мэдэгдэхүйц хамааралтай болох нь (Зураг 1) харагдаж байна.

Зураг 1

Фактор анализын үр дүн



Өөрөөр хэлбэл, судалгааны арга зүйн мэдлэг эзэмших хандлага ихсэх тутам судалгааны ажлыг хэрэглэх хандлага нэмэгдэж, улмаар судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлагад сайнаар шууд хүчтэй нөлөөлдөг

болох нь харагдаж байна. Хамаарлын хүчний коэффициентууд статистикийн ач холбогдолтой гарсан (Зураг 1, Хүснэгт1).

Хүснэгт 1

Корреляцийн шинжилгээний үр дүн

Пирсоны корреляцийн коэффициентууд		Судалгааны арга зүйн мэдлэг эзэмших хандлага	Судалгааны ажилд ач холбогдол өгөх	Судалгааны ажлыг хэрэглэх хандлага	Судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлага
Судалгааны арга зүйн мэдлэг эзэмших хандлага	Pearson Correlation	1	.801**	.747**	.702**
	Sig. (2-tailed)		.000	.000	.000
	N	47	47	47	47
Судалгааны ажилд ач холбогдол өгөх	Pearson Correlation	.801**	1	.618**	.711**
	Sig. (2-tailed)	.000		.000	.000
	N	47	47	47	47
Судалгааны ажлыг хэрэглэх хандлага	Pearson Correlation	.747**	.618**	1	.544**
	Sig. (2-tailed)	.000	.000		.001
	N	47	47	47	47
Судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлага	Pearson Correlation	.702**	.711**	.544**	1
	Sig. (2-tailed)	.000	.000	.001	
	N	47	47	47	47

Багшийн судлаач хандлагыг тодорхойлох ялгаа бүхий 4 дэд бүлгийн асуултууд тухайн бүлэгт тохирч буй найдварт чанарыг судлахад Chronbach а-ийн утга, математик

дундаж, стандарт хазайлтууд нь статистик ач холбогдолтой үзүүлэлтүүд гарсан нь багшийн судлаач хандлагыг хэмжихэд тохиромжтой болохыг харуулж байна. (Хүснэгт2).

Хүснэгт 2

Судалгааны найдварт байдлын шинжилгээний үр дүн

Үзүүлэлтүүд		Chronbach	Дундаж утга	Хазайлт
1	Судалгааны арга зүйн мэдлэг эзэмших хандлага	0,787	3.3649	0.76056
2	Судалгааны ажилд ач холбогдол өгөх хандлага	0,680	4.0216	0.60534
3	Судалгааны ажлыг хэрэглэх хандлага	0,804	3.2957	0.73558
4	Судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлага	0,716	3.4595	0.69600

2016-2017 оны элсэгч магистрантурын судлаач хандлагаа үнэлсэн өөрийн үнэлгээ болон төгсөх курсийн үнэлгээг харьцуулсан

харьцуулалт дараах байдалтай байсан бөгөөд шалтгааныг ярилцлага хийсэн дүгнэлтийг дараах байдлаар оруулав. (Хүснэгт3, График1).

Хүснэгт3

Судлаач хандлагын өөрийн үнэлгээний өөрчлөлт

	Судалгааны арга зүйн мэдлэг эзэмших хандлага	Судалгааны ажилд ач холбогдол өгөх хандлага	Судалгааны ажлыг хэрэглэх хандлага	Судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлага
Элсэгч магистрантур	10.8	67.6	8.1	13.5
Төгсөгч магистрантур	18.8	28.3	29.4	23.5
Өөрчлөлт %	8 өсөлт	39.3 бууралт	21.3 өсөлт	10 өсөлт

График 1

Судлаач хандлагын өөрийн үнэлгээний өөрчлөлт



Дээрх хүснэгт, графикаас харахад Судалгааны арга зүйн мэдлэг 8%-аар өссөн, үүний улмаас судалгааг хэрэглэх (21.3%), бүтээлчээр хийх хандлагууд (10%) өссөн байна. Харин Судалгааны ажилд ач холбогдол өгөх хандлага буурч байгаа нь судлуулагчийн судалгааны ажлын мөн чанарт хандах хандлагад өөрчлөлт орсонтой холбоотой байж болох юм. Үүнийг ярилцлагын аргаар гүнзгийрүүлэн судалсан болно. Ярилцлагын мэдээлэлд үндэслэн өөрчлөлтийн тайлбарыг хийвэл (Зураг 2):

Зураг 2

Nvivo програмын үр дүн



“Судалгааны ажлын аргазүй”, “Судалгааны програмын хэрэглээ” хичээлүүдээр судлах асуудал тодорхойлох, үе шат, өгөгдөл мэдээлэл боловсруулах, шинжилгээ хийх зэрэг үйл явцыг онолын болон судалгааны програмын хэрэглээтэй (SPSS, Nvivo) хослуулан орж буй нь бидэнд мэдлэг чадварын давуу талыг бий болгодог.

Судалгаа хийх ур чадвараа мэргэжлийн хичээлүүдээс олж авсан мэдлэг чадвартайгаа уялдуулан бүтээлчээр хөгжих боломж нэмэгдсэн. Ажлын ачааллаас шалтгаалаад судалгаа хийх цаг

зав хомс байдаг.

Судалгааны ажил хийх нь хэцүү боловч зайлшгүй хийх ёстой, хэрэгцээтэй зүйл болохыг бүрэн ухамсарлаж, хүлээн зөвшөөрдөг болсон. Иймд бусад судлаач багш нарын хийсэн судалгаанд анализ хийх, өөрсдийн ажилд тусган авч хэрэгжүүлэхдээ нээлттэй байдаг болсон. Ихэнхдээ Лавай, Боловсрол судлал, Социологийн сэтгүүлүүдийг уншдаг.

Судалгааны өгүүлэл, илтгэлүүдээс өөрт хэрэгтэй санаануудыг олж авах нь үр өгөөжтэй санагддаг, зарим нэг шинжлэх ухааны үг хэллэгийг ойлгоход бэрхшээлтэй байдаг.

МУБИС-ийн магистрант, докторантын ЭШХ-д оролцох төлөвлөгөөтэй байгаа тухайгаа 60% нь илэрхийлсэн гэх мэт.

Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан багш нарыг судлаач хандлагыг ялгаатай дөрвөн бүлэгт хуваасан боловсруулалтын үр дүн нь статистик ач холбогдол бүхий байна.
2. Судалгааны 20 асуулгын хүрээнд “Багшийн мэргэжлийн боловсролд судалгааны ажил чухал” гэсэн асуултад хамгийн их буюу 96%, “Эрдэм шинжилгээний хурал, семинарт судалгааны ажлаа хэлэлцүүлж түгээдэг” гэсэн асуултад хамгийн бага буюу 38% -тай хариулж байгаа нь багш нарын судлаач хандлага нь судлаач байх хандлагын ач холбогдлыг ойлгож ханддаг боловч бүтээлчээр судалгааны ажил хийх хандлагын төлөвшил доогуур байгааг харуулж байна. Гэхдээ “Эрдэм шинжилгээний хурал, семинарт судалгааны ажлаа хэлэлцүүлж түгээдэг” гэсэн асуултад хариулсан үзүүлэлт элсэх, төгсөх үеийн харьцаагаар 4%-аар өссөн.
3. Дэд бүлгүүдээр багцлан боловсруулалт хийсэн үр дүнгээс харахад (1, 2), (1, 3) ба (2, 4) дүгээр бүлгүүд хүчтэй хамааралтай, бусад бүлгүүдийн хооронд мэдэгдэхүйц хамааралтай болох нь (Зураг 1) харагдаж байна.

4. Судалгаанд хамрагдсан багш нарын өөрийн үнэлгээний өөрчлөлт нь тухайн суралцагчийн хандлагад эерэг өөрчлөлт гарсныг илтгэж байна. Судалгааны ажлыг хэрэглэх хандлага бүхий бүлэгт 21.3% өсөлт, Судалгааны арга зүйн мэдлэг эзэмших хандлага бүхий бүлэгт 8% өсөлт, судалгааны ажилд ач холбогдол өгөх хандлага бүхий бүлэгт 39.3% бууралт, судалгааны ажлыг бүтээлчээр хийх хандлага бүхий бүлэгт 10% өсөлт тус тус гарсан байна. Эндээс харахад судлуулагч нар судалгааны ажилд ач холбогдол өгөхөөс илүүтэйгээр судалгааны ажлыг хэрэглэх, бүтээлчээр хийх хандлага нэмэгдсэн.
5. Энэ судлаач хандлагыг илрүүлэх аргачлал нь онолын болон практик ач холбогдолтой байгаа тул багшийн мэргэжлийн хөгжил, ур чадварыг хөгжүүлэхэд ашиглах хэрэгсэл болох талтай.
6. Асуулга болон ярилцлагын өгөгдөл, мэдээлэл эерэг сонголтын хувьд харилцан адилгүй байсан. Асуулгын судалгааны үр дүн нь дараагийн ярилцлагын нотлох судалгааны үр дүнгээр батлагдаж байсан.
7. Багш сурган хүмүүжүүлэгчийн мэргэжлийн хөгжил хэмээх ойлголт нь багшийн судлаач хандлагатай салшгүй холбоотой болохыг энэхүү судалгааны ажлаар онцлон тэмдэглэж байна.

Ном зүй

- Andrew, M. Colman. (2006). Oxford dictionary of Psychology
- David, C. Berliner and Robert, C. Calfii (1996). Handbook of educational psychology (A project of Division 5, The Division of Educational Psychology of the American Psychological Association)
- David, G. Myers Psychology (1986). Worth Publishers, Ink
- Krathwohl, D. R. Bloom, B. S., & Mesia, B. B. (1964). *Taxonomy of educational objectives (Vol. 2): Affective domain*. New York: David McKay.
- Rohini, P.T. (2005). A Study of Attitude of Teachers towards Teaching Profession Teaching at Different Level, *International Multidisciplinary e – Journal / Rohini P.Trivedi* (24-30)
- Mary, E (2007). Dispositions in teacher Education. In the United States of America.
- Mike, S. (2001). Attitude teacher. In the United States of America.
- Joyce, W (2003). Preparing every teacher to reach english learner.

www.simplypsychology.org/

<http://www.radteach.com/>

МУБИС, Судалгааны арга зүйн тэнхим.(2018).

NVivo 11 програмын гарын авлага

МУБИС, Судалгааны арга зүйн тэнхим. (2017).

Судалгааны ажлын арга зүй

Master's study result that facilitate on teachers attitude

E.Oktyabrjargal, S.Battsetseg B.Bayarmaa, MNUE

Abstract

The MNUE development policy (2014-2024) has been planned in line with international trends and the country's educational policy aimed at training creative teachers with the potential to develop each child; an outcome based teacher education program is to be developed, implemented and regularly revised. By implementing this program our number of graduate students has increased by 1.6 times. Teacher educator's researcherly disposition refers to their state of mind when engaging with research - both as consumers and producers - to improve their practice and contribute to the knowledge base on teacher education. A researcherly disposition is defined as the tendency to engage in research, and involves an inclination towards research (affective aspect), an ability to engage in research (cognitive aspect) and a sensitivity for research opportunities (behavioural aspect). This is based on the methodology from "Measuring teacher researcherly disposition" on teacher education. In order to study this topic about we conducted interviews and gave paper survey questionnaires from sample of 20 percent of graduate students. Based on methodology "Measuring teacher researcherly disposition". The study comprised the following questions: 1. Being a smart consumer of research, 2. Being able to conduct research as a teacher educator, 3. Valuing research as a teacher educator, 4. Conducting research as a teacher educator. We used the SPSS-23 and NVivo-11 programmes for our data analysis. It is very important to measure research like disposition because teacher's need to have strong creative thinking and also professional development. Qualitative research methods including document analysis (analysis on expected outcomes of teacher programs at MNUE) and interviews have been used in the present study.

Keywords

Researcherly disposition, professional development, affective, cognitive, behavioural